

8. Гэмт явдлаас алба хаагчаа хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэх ажил, (Цагийн нөхцөл, байдал тухай ажиглуулах. Тусгай хэрэгсэл, тусгай мэх, галт зэвсэг хэрэглэх арга тактикийн асуудал гэх мэт).

Дээрхи асуудлыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үнд:

1. Төр, хууль санаачлах эрх бүхий субъект, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, цагдаагийн төв. нутаг дэвсгэрийн байгууллага, ажилтан, алба хаагчид нэг эрх ашгийн төлөө нэгдэж, цагдаагийн байгууллага, алба хаагчийн нийл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

2. Цагдаагийн төв байгууллагаас санаачилж байгаа алба хаагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр зохион байгуулж байгаа ажлыг бүхий л талаар дэмжин доромжилж, алба хаагчиддаа үзүүлэх захиргааны эрх зүйн хамгаалалтыг шинэ шатанд гаргаж, хүнийхээ төлөө тавих анхаарал халамжийг дээшлүүлж, улам бүр оновчтой зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Ингэснээр цагдаагийн алба хаагчийн захиргааны эрх зүйн хамгаалалтын тухай асуудлын мөн чанар, агуулга, ач холбогдол нь “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн¹” гэсэн үндсэн хуулийн заалтыг бодитой хэрэгжүүлэхэд тулгуур ойлголт болно.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн хошууч Ц.Адъяацэрэн*

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ХЭН УЛАМЖЛАЛ, ШИНЭТГЭЛ

Хүний нийгэм өөсч хөгжсөн үеэсээ гэмт явдлын улмаас өөсөх хор аюултай учирсаар ирсэн түүхтэй. Хүн төрөлхтөн гэмт явдлыг эвхэн хатуу чанд ял шийтгэлийн хичээр хориглон зогсоох боломжгүйг ухаарсан цагаас хойш, нийгмийн сөрөг үзэгдлийн хамгийн тод илрэл болсон гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тухай ойлголтыг бий болгожээ².

Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийгмийн арга хэмжээний хэлбэрийг тодорхойлохдоо уг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлж эхлэх үе,

¹ Монгол Улсын үндсэн хууль. 1992 онд батлагдсан.

² Г.Даштдэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. - УБ., 2007. 123 дах тал.

нийгэмд харш илрэлийн мөн чанар, онцлог түүнийг дахин давталтаас сэргийлэх зайлшгүй шаардлага зэргийг харгалзан эзэх нь зүйтэй юм¹.

Манай улс гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрт дээр өөс төрөл бүрийн арга, хэлбэрээр хийж ирсэн бөгөөд ардын хувьсгал ялсан нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинэ хэлбэрээр явуулах эхлэл болсон бөгөөд Ардын Засгийн газрын 1921 оны 7 сард болсон 6 дугаар хуралдаанаар дэг журам сахиулах, жинхэнэ ард төмний эрх ашгийг хамгаалагч “Сэргийлэх цэрэг”-ийг байгуулсан байна.

Энэ үйл явдлыг цагдаагийн байгууллагын төдийгүй аливаа хэрэг явдлаас урьдчилан сэргийлэх бодлогын эхлэл болсон гэж эдэг байна.

1923 онд Засгийн газрын хуралдаанаар олон төмөнд зориулсан анхны “Ухуулга бичиг”-ийг гаргаж, “Нийслэл хэрэний газар аливаа хөн архи уух, мөрийцөн наадах, хэрүүл шуугиан үдүүлэх, шүүнийн цагаар чимээ гаргах, гал усны аюул болох, хулгайлах, булаах зэрэг бөхийл гашуун самууныг цагдан байцаалгах”-ыг олон төмөнд сануулж, “...цаазалсаныг зөрчвөөс цээрлэн шийтгэх” журмыг эвшин батлан явуулсан байна.

Уг журамд, “Яамнаас зохих газруудад хөргүүлэн тушаасныг өөр өөрийн харъяат газруудаас олон дор зарлах тул ... аливааг ухамсарлан мэдэж, хичээнгүйлэн дагаж явбаас зохимой” гэсэн заалт нь хэрэг явдлаас урьдчилан сэргийлэх, төггөөр ч барахгүй төр, захиргаанаас эхлээд нийт байгууллага, иргэдийн эрхэм төггөр нь гэж тодотгож өгсөн чухал баримт болсон байна².

Тэр өөс эхлэн хууль ёсыг сахин биелүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон төмнийг татан оруулах талаар тухайн үеийн нам, төрийн байгууллагаас олон чухал арга хэмжээ авч байжээ. Улс орны хэв журмын нөхцөл байдалтай холбогдуулан, цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа дөнгөлт хийж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам³ хамгаалах үйл ажиллагааны бөгөөд, зохион байгуулалтыг сайжруулахад анхаарч иржээ.

Хууль хамгаалах байгууллагуудын нэг чухал зорилт бол, гэмт хэрэг нэг бүрийг илрүүлж, гэм буруутай этгээдэд зохих хариуцлагыг шударгаар оногдуулахын хамт гэмт хэрэг, зөрчил гарахад нөхцөлсөн шалтгааныг илрүүлж, цаг тухайд нь арилгуулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бөх аргаар зохиоход оршино⁴ гэж эзэж байжээ.

¹ Н.Жанцан. Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. - УБ., 1986.31 дэх тал.

² Л.Билгээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй - УБ. 2005. 11-12 дах тал.

³ Төм нь “нийгмийн хэв журам” гэсэн ойлголтоор хууль эрх зүйн нэр томъёонд хэрэглэж байсныг шинэчлэн зөрчлөн “нийтийн хэв журам болгосон.

⁴ Ж.Авхиа. Гэмт явдал, төмөнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал. - УБ. 1997. 159 дэх тал.

Олноо Үргэдсний 6 дугаар (1916) оны 12 дугаар сарын 30-нд Эзэн Богд хааны зарлигаар "Нийслэл хэрэний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм"¹ гэгчийг батлан гаргж энэхүү дүрмийн 5-р зүйлд "Нийслэл хэрэний тойрон газрыг найман анги хувааж, цагдан сэргийлүүлэх дор хялбар болгож бүр бүрийн хуваарийн газрууд дор дүр, шинэ өргөлжид сайтар харгалзан сахиж, цаг мөчийн түүдий ч осолдох. хийдүүлэхгүй болгон сайтар цагдан сэргийлүүлэе" гэж хэрэний нутаг дэвсгэрийг тодорхой 8 ангид хувааснаар нутаг дэвсгэр хариуцан ажиллаж эхэлсэн өө гэж үзэж болохоор байна. Түүнчлэн энэхүү дүрэм, журмын 23-р зүйлд "Аливаа цагдан сэргийлэгчид бүр бүрийн эрхэлсэн газрын доторхи аливаа хүний тус тусын аж ахуй, үйлдвэр явдал чухам ямар болох, аль аймаг хошуу шавийн хэн хэн, хэд болохын нэг зэрэг зан суртал байдал, дүрсийг нарийвчлан мэдэж хянаж баймой. Бас ч харьяат газрын дотор орон хашаа нэмэх, хасах, шилжин шүүх ба гадаад дотоодын олон хүний орох, гарах, оршин суух зэрэг аливаа элдэв олон учрыг урьхан сэмхнээр тагнан мэдэж харьяат албаны газар мэдүүлж, мөнхүү албаны газраас учрыг хянан тодорхойлон гаргах даруй дээд яамнаа уламжлан мэдүүлж хянан байцаахад бэлтгүүлвээс зохимой" гэсэн нь тухайн үеийн цагдан сэргийлэгчид бүр бүрсдийн хариуцсан нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаас гадна хянан шалгах үйл ажиллагаа давхар явуулж байсан нь харагдаж байна.

Энэ дүрмээр арван тавны цагдаа нь бүх гэрийн байдлаар олон жил ажиллаж ирснийг бүрчилж, цэрэг эрийн байдлаар томилж, хуарагнан байрлаж ажиллах зохион байгуулалттай болсон бөгөөд морьтой ба явган, тусгай ялгах тэмдэг бөхий албаны хантааз, хувцастай, зэвсэг хэрэглэх, нийслэл хэрэний нутаг дэвсгэрийг найман хэсэгт хувааж, хэсэг бүрт ажиллах цагдаагийн тоог хүртэл тодорхойлон заасан байна.

Олноо Үргэдсний 13 (1923) оны 5 дугаар сарын 13 нд Засгийн газраас "Цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ"-г 4 бөлөг, 42 зүйлтэйгээр баталсан³ нь Монгол Улсад ардын хувьсгал ялж, тухайн үеийн харийн түрэмгийлэгчдээс эх орноо чөлөөлсний дараа гэмт хэрэг, зүрчил гарахаас урьдчилан сэргийлэх, нийслэл хүрээг эмх журамд оруулах зорилготойгоор гарсан ихээхэн чухал шийдвэр байжээ. Энэ дүрэм хэмжээний гучин дүрвдгээр зүйлд "Харьяат хорооны газраа шийтгэн тасалсан эл хэрэг зүйлийг тухай бүр тодорхой томруунаар тогтоол бичиг зохион гарын үсэг зурж тусгай данс үйлдэн хянан байцаахуй дор бэлтгэхээс гадна басхүү нэгэн хувь сийрүүлэн торгосон ба хураасан мөнгөний хамт сар бүрийн эцсээр эрхлэн захирах яамнаа мэдүүлэн

¹ Т.Хүрэлбаатар, Д.Чулуунбат. Монголын цагдаагийн байгууллагын түүхийн зарим баримт бичгүүд. - УБ. 2011.9 дэх тал.

² А.Думбурай. Монгол бүрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. I дэвтэр. - УБ. 1999. 56 дах тал.

³ Т.Хүрэлбаатар, Д. Чулуунбат. Мөн тэнд. 24 дэх тал.

хянан байцааваас зохино” гэсэн нь тухайн үеийн цагдан сэргийлэгчид тодорхой нутаг дэвсгэр, хороо хариуцан 25 тэрлийн эрх, үүргийг гүйцэтгэж байсныг нотлож байна.

1924 оны 7-р сард Засгийн газрын хуралдаанаас хүн ам бөөгнөрсөн, гадаадын мөнгө хөдлөгчид төвлөрч байсан, тэнд хэв журам сахиулах зорилгоор Улиастай хотод бага дарга 1, цагдаа 4-ийг ажлуулахаар шийдвэрлэж байсан нь орон нутаг дахь анхны салбар болсон байна¹.

Түүний дараахан 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс “БНМАУ-ын цагдан сэргийлэх газрын дүрэм”-ийг 9 бөлөг, 73 зүйлтэйгээр батлан гаргасан байна. Энэхүү дүрмээр Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газар, түүний салбар хороод, хошуудын цагдан сэргийлэхийн зохион байгуулах журам, тэдгээрийн өөрсөд зорилтыг тодорхойлон заажээ.

1928 оны 1 дүгээр сарын 06-ны Засгийн газрын хуралдаанаар “Цагдан сэргийлэх газрын дагаж явах дүрэм”-ийг 10 бөлөг, 56 зүйлтэйгээр баталснаар³ эрүүгийн ба иргэний аар саар хэргүүдийн тухай, албан хаагчдын орон тооны тухай, харъяат алба хаагчдад олговол зохих цалин хэрэглэл зүйлийн тухай, чухал сахилга журмын тухай, явдал хичээлийн тухай, эрх зүйгийн тухай, гал түймэр сэргийлэн снүүх нь, буу зэвсэг хэрхэн хэрэглэх тухай аливаа хэргийн явуулга илтгэлийн тухай гэсэн бөлгүүдтэйгээр батлагдсан бөгөөд энэ нэгд хэрэг зөрчлийг цагдан сэргийлэхийн ажилтан шалгаад шууд шүүхэд шилжүүлдэг байжээ.

1941 онд МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 41 дүгээр тогтоолоор ардын цагдан сэргийлэхийн ажилд туслах сайн дурын бригадыг байгуулахаар шийдвэрлэж, дагаж мөрдөх журмыг баталсан нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ард олныг өргөнөөр оролцуулах шийдвэртэй алхам болжээ.

Энэ Үеэс эхлэн иргэд, хөдөлмөрчдөөс цагдаагийн байгууллагад идэвхитэй туслах хөдөлгөөн амжилттай Үргэж ирсэний учир, улс орны Үндэсний аюулгүй байдал, эрхийн нөхцөл байдал тогтворжиж, иргэдийн эрх чөлөөг хамгаалах асуудал нэлээд баталгаажиж ирсэн байна.

Түүр засгаас дэс дараатай олон арга хэмжээ авсаны үр дүнд, Цагдаагийн байгууллага жилээс жилд бэхжин, 1947 онд улсын хэмжээнд гэмт хэргийн дүнгүж 50 хувийг илрүүлж байсан бол 1951 онд 74%, 1954 онд 83%, 1958 онд 92%-ийг илрүүлдэг болсон байна. Энэ нь улс орны хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх ажил жилээс жилд эрчимжиж байсны илрэл юм⁴.

¹ А.Думбурай. Монгол түүрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт. I дэвтэр. УБ. 1999.

77 дах тал

² Т.Хүрэлбаатар, Д. Чүлүүнбат. Мн тэнд. 30 дах тал

³ ТХүрэлбаатар, Д. Чулуунбат. Мн тэнд. 9 дэх тал

4 ГДашт дэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. - дУБ., 2007. 23 дах тал.

Улс орны хөгжил, дайны бейн бйл ажиллагааны улмаас Сайд нарын Зөвлөлийн 1942 оны 4-р сарын 14-ны бдрийн хурлаар цагдан сэргийлэх байгууллагын 1936 оны дбрийг шинэчилж, “Дотоод явдлын яамны харъяа Улсын цагдан сэргийлэх газрын дбрэм¹” нэртэй 3 бөлэг 22 зйлтэй дбрийг УБХ-ын Тэргүүлэгчид батлан мрдүүлжээ.

1952 онд ДЯЯ-ны сайдын 170 тоот тушаалаар УЦСГ-т сэргийлэн хамгаалах ба хотын ЦС-ыг хариуцсан орлогч даргын орон тоо бий болгожээ. ЦСГ-ын сэргийлэн хамгаалах болон байлдааны бэлтгэл хэлтэс энэ орлогч даргын удирдлагаар ажиллаж, Нийслэл хотын арван хороог хариуцсан ЦС-ын таван анги, нэг хэсэг байгуулагджээ.

Энэ нь хэв журам сахиулах ажлын хэрэгсэл, гэмт хэрэг злчилтэй тэмцэх ажил сайжирч байсныг харуулж байна².

1955 оны 3 сарын 29-нд Сайд нарын Зөвлөлийн 129 дгээр тогтоолоор ЦСБ-ын 1942 оны дбрийг шинэчилж, ерөнхий анги, эрх злрэг, зохион байгуулалт гэсэн гурван хэсэг, 17 зйлтэй “БНМАУ-ын Дотоод явдлын яамны харъяа Улсын цагдан сэргийлэхийн дбрэм³” нэртэйгээр баталж, ЦСБ-ын шинж чанар, зорилт, ажиллах зарчим, гийцэтгэх злрэг, эрх ба зохион байгуулалтыг нь тодорхойлж гчээ.

Энэ дбрмээр хэв журам сахих тухай шаардлага тавих, злрчлийг арилгах талаар хууль ёсны арга хэмжээ авах, гэмт хэрэг бйлдэгч, злрчил гаргагчдыг баривчлах, ууж согтуурсан хмбсийг барьж эрүүл болтол нь байлгах, иргэд, албан хаагчдыг дуудах, нэгжлэг хийх, хураан авах, гэмт хэрэгт сэжиглэгдсэн ба хорихоос оргосон хмбсийг мрдүн хлж, эрэн сурвалжлах, гэмт хэргийг таслан зогсоох, хэрэг бртгэлт, мрдүн байцаалт явуулах зэрэг эрхтэй болохыг заажээ. Мн дбрийн 6-р зйлд анх удаагаа хэсгийн тлүүлгч, байцаагчийн Пэрхийг тусгайлан оруулж гсүн нь энэ беес эхлэн сэргийлэн хамгаалах байцаагч нар тусгайлсан эрх злргийг гийцэтгэж эхэлсэн гэж бэж болохоор байна.

1960 онд, МАХН-ын Тв Хорооны 170 дугаар тогтоол гарч, хдлмрчдийн дунд хууль сурталчилах олон хэлбэрийн ажил зохиох, гэмт хэрэг, злрчил гаргаж болзошгй хмбстэй нэг брчлэн уулзаж, хмбжлийн ажил хийх, эргүүл шалгалтыг хчтэй болгож, гэмт хэрэг гарч болох байдлуудыг урьдчилан илрүүлж арилгах ажлыг нам, улс, олон нийтийн байгууллага, хдлмрчин олон тмний туслалцаатайгаар зохион байгуулж эхэлсэн байна. Мн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд олон тмний оролцоог сайжруулах зорилгоор аймаг, сум, дбрэг брт “Нийгмийн хэв журам хамгаалах

¹ Т.Хүрэлбаатар, Д. Чулуунбат. Мн тэнд. 57 дах тал.

² А.Думбурай. Монгол тбрийн цагдаагийн уламжлал, тбхэн хгжилт. - УБ. 1999. 174 дэхтал

ТХүрэлбаатар, Д. Чулуунбат. Мн тэнд. 57 дах тал.

түв”-ийг байгуулан сум, дүүрэг, хорооны дарга нарыг түвийн даргаар сонгон ажиллуулж байсан нь гэмт хэрэгтэй тэмцэхэд олон түмнийг татан оролцуулсан шалгарсан аргын нэг болсон байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хичтэй болгохын тулд хуулийн байгууллагын ажлын уялдааг сайжруулах асуудал цоо шинээр тавигдсан учир 1961 оны 1 дүгээр сарын 14-нд Улсын прокурор, Улсын дээд шүүх, НАХЯ-ны сайдын 12/38/9 тоот хамтарсан тушаал гаргаж, Намын түв хорооны 1960 оны "Гэмт хэрэгтэй тэмцэхэд намын байгууллагын зорилтын тухай" 170 дугаар тогтоол, мөн онд болсон хуулийн байгууллагын удирдах ажилтны зөвлөлийн шийдвэрийг хич хавсран биелүүлэх тухай нарийвчлан заасан нь зарчмын чухал ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

1985 оны 3 дугаар сарын 29-ны 1-дрийн АИХТ-ийн 96 дугаар зарлигаар "Цагдан сэргийлэх байгууллагын 1-ндсэн дүрэг, эрхийн тухай" батлан гаргажээ. Энэ зарлигийн 1-ндсэн дээр Сайд нарын Зөвлөл 1985 оны 4-р сарын 26-ны 1-дрийн 95 дугаар тогтоолоор ЦСБ-ын дүрмийг "БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм" нэртэйгээр 6 бүлэг, 32 зүйлтэйгээр шинэчлэн баталсан байна. Ингэж цагдан сэргийлэх байгууллагын эрх зүйг шинэчлэх ажил явагдаж, "Түүцэтгэх ажлын заавар", "Эргүүл постын заавар", "Сахилга батын дүрэм", "Хүдлэмж рчдийн гомдлыг барагдуулах тухай" заавар, "Гэмт хэргийг илрүүлэх арга тактикийн тухай" зэрэг олон заавар дүрмүүд батлагдан хэрэгжиж иржээ.

1990 онд ардчилсан хувьсгал гарч, нийгмийн тогтолцоо бүхлээрээ өөрчлөгдөх тэр цаг мөчид цагдаагийн байгууллага өөргөө хэрэгжүүлэх чадвар, сахилга хариуцлага, ёс зүй, мэдлэг боловсролыг ямагт дээшлүүлж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн сахиж, түрийн хуулийг хэрэгжүүлэх ажлыг цагдаагийн байгууллагын бүх шатанд зохион байгуулалт, шаардлагын 1-ндр хэмжээнд үйл ажиллагааны өргөн цар хүрээтэй зохион байгуулах явдлыг эрхэмлэн ажиллахыг цаг өө шаардаж эхэлсэн байна.

1993 оны 12 дугаар сарын 02-ны 1-дүр Монгол Улсын Улсын Их Хурлаас "Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль"-ийг 8 бүлэг 53 зүйлтэйгээр батлан гаргасанаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөхс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ бүтэц, зохион байгуулалттайгаар явуулах нөхцөл боломж бүрдсэн юм.

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил олноор гарч, түүнээс иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид учруулах хохирол нэмэгдсээр байгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцлийг улам хичтэй болгохын зэрэгцээ шинэлэг арга барилаар ажиллах шаардлага зүй ёсоор гарч байна.

¹ Г.Даштү дэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. - УБ. 2007. 23 дахь тал.

² Т.Хүрэлбаатар, Д. Чулуунбат. Мөн тэнд, 57 дахь тал.

Нийтийн хэв журам хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хууль ёс, эрх зүйн дэг журмыг бэхжүүлэх нь зөвхөн цагдаагийн төдийгүй, төр, олон нийтийн бусад байгууллага, албан тушаалтан, бусад хамтаар хамааралтай нийгмийн бүртгэн хэрэгтэй ажил юм. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын эцсийн зорилго нь ноцтой, аюултай үйлдэл болох гэмт хэрэг, зөрчлийг багасгах, улмаар төлөнд нөлүүлж байгаа хүчин зүйлсийг арилгах, ард иргэдийн амгалан тайван байдал, ая тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх асуудал байдаг¹.

Гэмт хэрэг, хэв журмын зөрчил хаана олноор гарч, согтуугаар үйлдэгдэж байна, тэнд үйл ажиллагаа сул, зохиосон ажлын төр нөлөө хангалтгүй байгаагийн илрэл гэж дүгнэж болох юм.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн ахмад П.Ганхуяг*

**ЦЭНХ МОНГОЛЧУУДЫГ МИНЬ
АВТО ОСОЛ ГЭГЧ “ДАЙН” АВЧ ОДСООР БАЙХ УУ? ...
(Асуудал дэвшүүлж, шийдвэр хүлээсэн нийтлэл)**

“Монгол Улсын хэмжээнд 2012-2020 онд зам тээврийн ослын улмаас нас барсан болон хүнд гэмтсэн хүний тоог тус бүр 50 хувиар бууруулна”.

Та ийм Уриа ч юм уу, эсвэл зорилт, зорилго хаа нэгтээ бичигдсэн байхыг олж харсан уу? Гүйл болов уу?

Тэгвэл Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 5 сарын 2-ны өдрийн 146 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги 2012-2020²”-ийг батлан гаргаж төлөнд энэхүү зорилтыг тусгасан байдаг.

Дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жилд 1,2 сая гаруй хүн амь насаа алдаж, 50 сая гаруй хүн бэртэж, гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн зэрэгцээ 5-29 насны хүүхэд, залуучуудын өхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна. Зам тээврийн осол нь зөвхөн шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа бөгөөд зам тээврийн ослоор нас барагсдын 90 гаруй хувь нь буурай болон хөгжиж байгаа улс оронд ногдож, жилд нийт 65 тэрбум ам.долларын хохирол учирч байгааг НҮБ-аас онцлон тэмдэглэж, 2010 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаанаас 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жил” болгон зарлаж 64/255 дугаар тогтоолыг гаргаж, зам тээврийн ослыг эрс багасгаж, нас баралтыг 50 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

¹ Д. Таванжиг. Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажил, төлөний төр нөлөөг дээшлүүлэх зарим асуудал. - УБ. 2002. 19 дэх тал.

² Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/9502>